# Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Зорилт 1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг | | | | |
| 1.1 | 1.1.Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх. | 1.1,1.Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх. | Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын цалингийн шатлал нэмэгдүүлэх, зэрэг дэв олгуулах зэрэгт сахилгын шийтгэл авсан албан хаагчдыг хамруулдаггүй. Ур чадварын нэмэгдлийг төрийн үйлчилгээний 4 албан хаагчид олгон ажиллаа. Сахилгын шийтгэлгүй болон мэргэжил ур чадвар нь шаардлага хангаж байгаа албан хаагчдыг шагналд тодорхойлох, зэрэг дэв нэмэгдүүлэх, шатлал ахиулах зэргээр дэмжин ажиллаж байна. | 100 |
| | | 1.1.2.Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох. | 2024 онд шинээр томилогдохоор төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын 3, улс төрийн албан тушаалтан 2 нийт 5 албан хаагч нэр дэвшгдсэн бөгөөд албан хаагчдын ХАСУМ-ыг Авлигатай тэмцэх газраар хянулсны үндсэн дээр томилуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1.1.3.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн баримтад хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн тогтоол, дүгнэлтийг хавсаргах. | Урьдчилсан мэдүүлгийн баримтанд төрийн албан хаагчийн анкет, албан тушаалын тодорхойлолт, ИТХурлын тэмдэглэл, аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн тогтоол албан тоотын хамт хүргүүлж байна. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1.1.4.Төрийн жинхэнэ албан тушаалаас төрийн жинхэнэ албаны нөөцөд байх үндэслэлээр түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох. | Энэ онд төрийн жинхэнэ албанаас 1 иргэн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн. Чөлөөлөгдмөгч ажлын байрыг зарлуулж, аймгийн ТАСЗ-д албан бичгээр сул орон тооны захиалгыг хүргүүлсэн. ТАСЗ-өөс сул орон тооны тусгай шалгалтын зарлалыг тавингуут шэйрлэж сумынхаа цахим хуудсуудаар тавьдаг. Түр чөлөөлөгдсөн албан хаагч байхгүй болно. | 100 |
| 1.2 | 1.2.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, нийтийн албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх. | 1.2.1.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах. | Төрийн албан хаагчдад хариуцсан салбар чиглэлээр нь дээд байгууллагаас нь тухай бүр цахимаар сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. Удирдлагын академийн алсын зайн богино дунд хугацааны сургалтанд 1 албан хаагч суралцаж сертифкат авсан. | 100 |
| | | 1.2.2.Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. | Мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх хүсэлт тавьбал бүх талаар дэмжихэд бэлэн байдаг. Энэ онд суралцахаар хүсэлт өгсөн албан хаагч байхгүй байна. | 90 |
| | | 1.2.3.Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. | Төрийн албаны зөвлөлөөс явуулж буй цахим сургалтанд Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх сургалтанд 3 албан хаагч хамрагдсан.<br>ЕБС, СӨББ, Соёлын төв, ЭМТөв, Туяа ЕБС-ийн албан хаагч нарт авлигатай тэмцэх, чиглэлээр зөвлөгөө өгсөн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.3 | 1.3.Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх. | 1.3.1.Төрийн байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх. | Ёс зүйн хороог сумын төрийн байгууллага бүр байгуулсан. Засаг даргын тамгын газрын хувьд албан хаагчид тогтвор суурьшилгүй ажиллаж сул орон тоо ихтэй байсан учраас энэ оны байдлаар ёс зүйн хороо тогтмол үйл ажиллагаа явуулж чадаагүй.Оны эхэнд Ес зүйн хорооны гишүүдийг шинэчлэн баталсан. Байгууллагын албан хаагчдын дунд 1 удаа арга хэмжээ зохион байгуулсан. Ёс зүйн тухай хуулиар байгууллага бүр албан хаагчиддаа мэдээлэл хийсэн. Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн баталж Албан хаагчдын албан тушаалын чиг үүргийн дагуу хяналт тавьсан. Гарсан зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажилласан. | 90 |
| | | 1.3.2.Төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих. | Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн ил тод байдал, хүний нөөцийн систем, ёс зүйн хуулийн хэрэгжилт, тушаал, шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, бодлогын барим бичгийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг сумын Засаг даргад танилцуулан байгууллагын дарга нарт зөвлөгөө өгч алдаа, зөрчлийг арилгуулсан. | 100 |

| Зорилт 2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыгхангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх. | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1 | 2.1.Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх. | 2.1.1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах. | Төрөөс үзүүлж буй цахим үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор E Mongolia цахим сангаас иргэдэд лавлагаа мэдээлэл гаргаж өгөхөд 1 албан хаагчийг сургалтанд 4 хоног хамруулсан. Хариуцсан албан хаагч өөрчлөгдөж ERP програмын сургалтанд 1 албан хаагчийг хамруулж байна. Бусад нийгмийн даатгал, улсын бүртгэл, халамжийн үйлчилгээг цахимаар үзүүлэхэд иргэдэд онлайнаар сурталчилан зөвлөгөө мэдээллийг тухай бүр өгч ажиллаж байна. Мөн 4, 6, 9-р саруудад болсон багийн ИНХурлууд дээр малчдад гар утсанд нь апликэйшин суулгаж заавар зөвлөгөөг өгч ажилласан. | 100 |
| 2.3 | 2.3.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах. | 2.3.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх. | Төрийн байгууллагуудын албан хаагчид тогтвор суурилгүй ажиллаж, сул орон тоо ихтэй байсан учраас хөндлөнгийн үнэлгээ болон иргэдээр үнэлүүлэх ажлыг зохион байгуулаагүй болно. Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг гаргаж сумын ИТХ болон аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан. Энэ онд төрийн үйлчилгээг иргэд үнэлэх боломжийг нээгээгүй байна. | |
| | | 2.3.2,Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх. | | 70 |
| | | 2.3.3.Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх. | | |

| Зорилт 3.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх. | | | | |
|---|---|---|---|---|
| 3.1 | 3.1.Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх. | 3.1.1.Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажпыг зохион байгуулах. | Шилэн дансны мэдээллийг shilendans.gov.mn хаягаар авч болно. Шилэн дансанд нийт 1013 мэдээлэл байршуулснаас 1.8 хувь хугацаа хоцорсон нь урд оныхоос 1.4 хувь буурсан үзүүлэлттэй байна. Төсвийн гүйцэтгэл, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэрэг мэдээллийг шилэн данс, сумын вэб сайт, мэдээллийн самбарт байршуулан мэдээллэж байна. ХАА-ны төлөвлөгөө, тендерийн бичиг баримт, үнэлгээний хорооны талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны Tender.gov.mn-д байршуулан, бүх тендер цахимаар зарлагдан явагдаж байна. Мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр сумын вэб сайт, page хуудсаар, мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн. Санхүүгийн хяналт аудитын хэлтэс, Сумын Дотоод хяналт нэгжээс 2022 оны шилэн дансны 1.2.3-р улирлын байдалд хяналт тавьж ажилласан. Хяналт шалгалтаар илэрсэн алдаа тухай бүр засуулан ажилласан | 100 |
| | | 3.1.2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийн ил тод байдлын үнэлгээг хийж, холбогдох журам, дүрэмд өөрчлөлт оруулсан байх. | | 100 |
| 3.2 | 3.2.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруула | 3.2.1.Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах. | 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг, санал асуулгын хуудсаар авч нэгтгэн багийн Иргэдийн нийтийн хурлаар эрэмбэлүүлж, иргэд олон | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | х,<br>аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлага тооцох, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах,<br>хариуцлаг ыг<br>дээшлүүлэх. | 3.2.2.Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, ОЛОН НИЙТЭД мэдээлэл хүргэх. | нийтийн саналыг тусган ажиллаж байгаа. Санал асуулгын хуудсаар нийт 568 иргэн, цахим санал асуулгаар 41 иргэн санал өгсөн. Багийн иргэдийн нийтийн хуралд 368 иргэн суусан байна. | 100 |
| | | 3.2.3. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас төрийн (захиргааны) байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх. | байхгүй | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6. | 6.1.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх. | 6.1.1.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлж, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх. | Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хүлээж авах ажлын хэсэгт иргэдийн төлөөллийг заавал оролцуулдаг. Жил бүрийн ОНХС-ын санал авахдаа иргэдийг 100 хувь оролцуулах чиглэл барин ажилладаг. | 100 |
| | | 6.1.2.Сум, байгууллагын түвшинд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж, биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнах, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд удирдлагын манлайллыг хэрэгжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоог бууруулах, таслан | Авлигын эсрэг 2024 оны ажлын төлөвлөгөөг төрийн байгууллага бүр гарган сумын Засаг даргаар батлуулан ажилласан. Авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор төсөл хөтөлбөр хэлэлцсэн ажлын хэсгүүд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг тухай бүр гаргасан. Тарагт сумын вэб хуудас болон фэйсбүүк-д тухай бүр мэдээллүүдийг тавьж байршуулан ажиллаж байна. | 100 |
| | | 6.1.3.Засгийн газрын 2021 оны 109 дүгээр “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах. | | 70 |
| | | 6.1.4.Сум, агентлагуудын албан ёсны цахим хуудас ашиглалтыг сайжруулах, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тодорхой хөрөнгө мөнгө шийдвэрлэн, зарцуулах. | | 70 |

Зорилт 7. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх.

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7. | 7.1.Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх. | 7.1.1.Төрийн байгууллагууд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах. | Төрийн байгууллагуудын ажил үйлчилгээ болон төсөл хөтөлбөрүүдийн талаар дараа оны 1-р сард багтаан сонинд нийтэлж айл өрх бүрт тараан мэдээллэж хэвшсэн. | 100 |
| | | 7.1.2.Авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах, хамтарч ажиллах. | Авлигатай тэмцэх газраас иргэдэд мэдээллэхээр тавьсан шторк, цахим мэдээллүүдийг сумын цахим хаягуудаар тавьж сурталчилан ажилладаг. Байгууллагын орох гарах хаалга, хананд Авлигын эсрэг сурталчилгааны зураг болон 110 утасны талаарх мэдээллийг байршуулсан. | 100 |

| Зорилт 4.Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх. | | | | |
|---|---|---|---|---|
| 4.1 | 4.1 .Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх. | 4.1.1 .Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаашид тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж хэвшүүлэх. | Орон нутгийн хөгжлийн сан, төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх худалдан авах ажиллагааг Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан ерөнхий төлөвлөгөөг www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хэлтэсээр батлуулж, Tender.gov.mn сайтад нийтэлсэн. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Босго үнээс давсан нийт зарлагдаж буй тендерийг 100 хувь цахимаар явуулж, | 100 |
| | | 4.1.2.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах. | | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 4.1.3.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж мэдээлэх. | тендер шалгаруулалт, гарсан үр дүнг тухай бүр мэдээллэн ажиллаж байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудас, сумын вэб сайтандаа байршуулан | 100 |
| Зорилт 5. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх. | | | | |
| 5. | 5.1.3ах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. | 5.1.1.3ах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр өрсөлдөгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, ёс суртахуунтай, өрсөлдөөнт орчин бүхий бизнесийг дэмжин хөгжүүлэх. | 2024 онд сумын хэмжээнд дэмжиж хөгжүүлэх бизнес үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлуулж, түүний дагуу Хоршоо хөгжүүлэх сангаас нийт 112 сая төгрөгийг 16 иргэнд олгосон. | 100 |
| ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх. | | | | |